

Уул уурхайн жишиг сургууль

Говьсүмбэр политехник коллеж

ИЛТГЭЛ

Илтгэлийн сэдэв: Дадлагын удирдамжийг сайжруулснаар ажил олгогчийн хамтын ажиллагаа болон ҮСД-д гарах үр дүн

Илтгэгч: Эдийн засгийн багш, Бизнесийн удирдлагын магистр /М.Баярмаа/

Мэдээлэл технологийн багш /М.Сандагсүрэн /

Говьсүмбэр аймаг

2020 он

Агуулга

Агуулга	2
Зураг.....	3
Түлхүүр үг.....	4
Судалгааны үндэслэл:	4
Судалгааны ажлын зорилго:.....	4
Судалгааны зорилтууд:	4
Судалгааны арга зүй.....	5
НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛЫН АРГА ЗҮЙ.....	6
1.1. МБС-ын тухай хуулийн зүйл заалт	6
1.2 Дадлага гэж юу вэ?	8
ХОЁР ДУГААР БҮЛЭГ: СУРГУУЛЬ ДЭЭРХ ДАДЛАГА АЖЛЫН ТУРШИЛТ СУДАЛГАА	10
Судалгаа: 2-1 Өөрийн орж буй хичээлийн сургууль дээрх дадлага ажлыг “Дадлагын хөтөлбөр” боловсруулан орсон туршилтын судалгаа	10
Судалгаа: 2-1-ийн дүгнэлт	12
Судалгаа: 2-2 “Дадлагын хөтөлбөр” боловсруулан орж буй багш нарын тандалт судалгаа	13
Судалгаа: 2-2-ийн дүгнэлт	14
ГУРАВ ДУГААР БҮЛЭГ: НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, АЖ АХУЙ НЭГЖИД ХИЙГДСЭН СУДАЛГАА	15
Судалгаа: 3-1 Дадлагын удирдамжийн харьцуулсан судалгаа	15
Судалгаа: 3-1-ийн дүгнэлт	17
Судалгаа: 3-2 Үйлдвэр аж ахуй нэгжид ҮСД-ыг хэрхэн зохион байгуулж буйд хийгдсэн судалгаа	18
Судалгаа 3-2-ийн дүгнэлт	19
Судалгаа:3-3 Дадлагын удирдамжид дадлагын хөтөлбөрийг сайжруулж оруулснаар ҮСД-д гарах үр дүнгийн өөрчлөлт болон ажил олгогч, үйлдвэр, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх боломж	20
Ерөнхий дүгнэлт	21
Ном зүй.....	22

Зураг

Зураг 1: ГС ПТК хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө	10
Зураг 2: Дадлагын хөтөлбөрийн загвар жишээ	11
Зураг 3: Сургууль дээрх дадлагын хөтөлбөрийн үнэлгээний хуудас	14
Зураг 4: Техникийн боловсролын ҮСД-ын удирдамжийн хэсгээс	15
Зураг 5: Мэргэжлийн боловсролын 2,5 жилийн танилцах дадлагаын удирдамжийн хэсгээс ..	16
Зураг 6: Үйлдвэр дээрх дадлагын удирдамжийн загвар	20

Түлхүүр үг

- Дадлагын хөтөлбөр
- ҮСД
- Нийгмийн түншлэл
- Дадлагын удирдамж

Судалгааны үндэслэл:

ХНХЯ-ны сайд асан С.Чинзориг “Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн хандлага-мэргэжлийн багийн шинэ дүр төрх”-ийг танилцуулжээ

Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын салбар өнөөдөр цоо шинэ тогтолцоо руу шилжин орж байна. Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ, ажил олгогчийн үр чадварын эрэлтэд суурилсан агуулга, арга зүйн шинэчлэл, аж ахуйн нэгж, ижтэй техниккийн ажилтан, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор сургалтын нийт байгууллагаудад идэвхитэй хэрэгжиж ирсэн.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд мэргэжлийн боловсрол, сургалтын 84 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Түүний 51 нь төрийн, 33 нь төрийн бус өмчийнх байна. Эдгээр сургуулиудад 38.526 оюутан 16 салбарын 230 гаруй мэргэжлээр суралцдаг. Мэргэжлийн салбараар авч үзвэл 28.2 хувь нь аж үйлдвэрийн, 19.4 хувь нь барилгын, 12.0 хувь нь тээврийн, 7.0 хувь нь уул уурхайн, 5.9 хувь нь үйлчилгээ, 27.5% хувь нь бусад салбарын чиглэлээр сурч буй юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтын шат шатны удирдлагын түвшинд хувийн хэвшил-үйлдвэрлэлчид, мэргэжлийн холбоодын оролцоо буй болсон боловч, түншүүд, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжилтэй ажилтан бэлтгэх тулгамдсан асуудлуудад нэгтгэн чиглүүлэх, тогтмол ажиллуулал, салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг хангах явдал дутагдалтай явж ирсэн.

Манай яам, агентлагууд өөр өөрийн салбарын хөгжлийн бодлогын хүний нөөц, ажиллах хүчний асуудлаар хамтран ажиллах салбар дундын зохицуулалтын механизмийг тодорхойлж, хүч, боломжоо нэгтгэх нь амжилтанд хүрэх үндэс болно.

Судалгааны ажлын зорилго:

- Дадлагын хөтөлбөр боловсруулан ҮСД-д хэрэгжүүлснээр гарах үр дүнг туршилтаар харуулан, цаашид ажил олгогч, аж ахуй нэгжүүдэд нэвтрүүлэх боломжийг судлах

Судалгааны зорилгууд:

- Онол арга зүйг судлах
- Сургууль дээрх дадлагын үр өрөөжийг судлах
- Дадлагын удирдамжид хийх харьцуулсан судалгаа
- Ажил олгогч болон дадлагажигчийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох
- Харьцуулсан судалгаануудад дүн шинжилгээ хийж шинэ санаа гаргах

Мэргэжлийн боловсролын салбарын багш нарын анхдугаар зөвлөгөөн 2019он- Сайд асан Чинзоригийн илтгэл

Судалгааны арга зүй

Мэдээлэл түүвэрлэх, эх сурвалжийн анализийн аргыг сэдвийн судлагдсан байдлыг тогтоож онолын хэсгийг боловсруулахад, ярилцлагын аргыг бусад мэргэжлийн багш нар болон үйлдвэр уурхайн инженер техникийн ажилтнаас туршлага судалж дүгнэлт хийн шинэ санаа гаргахад, ажиглалт болон харьцуулалтын судалгааны аргыг туршилтын явцад гарч буй өөрчлөлт үр дүнг баримтжуулж, нотолгоожуулахад, статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийхэд тус тус хэрэглэв.

НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ: ОНОЛЫН АРГА ЗҮЙ

1.1. МБС-ын тухай хуулийн зүйл заалт

МБС-ын тухай хуулинд ҮСД-ыг зохион байгуулах мөн нийгмийн түншлэлийн хамтын ажиллагаа оролцоог хуульчилсан байдаг.

11 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын ажлын зохион байгуулалт

11.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь танхимын хичээл, үйлдвэрлэлийн сургалт, дадлагын ажил байна.

11.2. Үйлдвэрлэлийн сургалт, дадлагын ажлыг сургууль дээрх, ажлын байран дахь, төгсөлтийн өмнөх гэсэн үе шаттайгаар зохион байгуулна.

11.3. Мэргэжлийн боловсрол, сургалт нь өдрийн, оройн, хосмог, хөдөлмөр эрхлэлтийн зэрэг хэлбэртэй байж болно.

/Энэ хэсгийг 2012 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

11.4. Үйлдвэрлэлийн дадлагын ажил хийлгэх асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, сургууль гурван талт гэрээ байгуулна.

11.5. Тавиас дээш ажилтантай аж ахуйн нэгж суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх үүрэг бүхий дадлагажуулагч багш ажиллуулна.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн/

20 дугаар зүйл. Нийгмийн түншлэл

20.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, эцэг, эх зэрэг сонирхогч этгээд нийгмийн түншлэлийг бүрдүүлж, зөвлөлийн хэлбэрээр ажиллаж болох бөгөөд дараахь түвшинд ажиллана:

20.1.1. салбарын түвшний нийгмийн түншлэлийг салбарын яам, агентлаг, мэргэжлийн холбоод, ажил олгогч, эцэг, эхийн төлөөлөл бүрдүүлэх;

20.1.2. орон нутгийн нийгмийн түншлэлийг нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, эцэг, эх бүрдүүлэх;

20.1.3. сургалтын байгууллагын нийгмийн түншлэлийг аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, эцэг, эх, суралцагч бүрдүүлэх.

/Энэ хэсгийг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

20.2.Нийгмийн түншлэл нь дараахь чиглэлээр хамтран ажиллана:

20.2.1.мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого боловсруулахад оролцох;

20.2.2.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах;

20.2.3.мэргэжлийн хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, сургалтын агуулга, стандарт боловсруулахад оролцох;

20.2.4.Үйлдвэрлэлийн сургалт, дадлагыг хамтран зохион байгуулах;

20.2.5. Багш нарын мэргэшил дээшлүүлэх;

20.2.6. Мэргэжлийн шалгалт хамтран авах;

20.2.7.суралцагчийн сурлагын амжилт, мэргэжлийн ур чадварыг ажил олгогчдод мэдээлэх, дадлагажуулах, төгсөгчийн сонирхолд тулгуурлан ажлын байранд зуучлах, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих замаар ажлын байраар хангах;

/Энэ заалтыг 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

20.2.8.багш, инженер-техникийн ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

20.2.9.үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хамтран явуулах;

20.2.10.хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

20.3. Салбар, үйлдвэрийн онцлогоос хамааран аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд цалингийн сангаасаа энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлөөс тогтоосон тодорхой хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

1.2 Дадлага гэж юу вэ?

Оюутан, суралцагчид танхимын сургалтаар эзэмшсэн онолын мэдлэг, чадвараа практик үйл ажиллагаатай холбон бататган гүнзгийрүүлж, ажиглалт, судалгаа, боловсруулалт хийх чадвар, дадал эзэмших, өөрийн мэргэжлийн салбарт тавигдаж буй зорилт, тулгамдсан асуудлын талаар тодорхой мэдээлэл олж авах, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай үр чадваруудыг эзэмших зорилготой суралцах үйл ажиллагааг дадлага гэнэ.

Интерншип гэж юу вэ?

Суралцахынхаа зэрэгцээ өөрийн эзэмшиж буй мэргэжлийн чиглэлээр болон ямар нэгэн албан байгууллагад дадлага хийнгээ ажиглахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл оюутан дадлага хийх явцадаа цалин авах мөн сургуулиа төссөн хойно нь ажиглагч авах зэргээр тохиролцон дадлага хийнгээ ажиглаж болдог хөтөлбөрийг хэлнэ.

Дадлага яагаад чухал вэ?

- Оюутан өөрийн эзэмших гэж буй тухайн мэргэжлийн танхимд сурсан үр чадваруудыг практик дээр суралцах
- Онолын мэдэгдэхүүнийг амьдралд бодитойгоор туршиж үзэх боломж
- Ажлын хамт олонд орж ажигласнаар ажиг олгочтой танилцах мөн харилцааны үр чадвар дээшлэх боломж нээгдэнэ, өөрөөр хэлбэл танилын хүрээгээ тэлнэ.
- Ажил олгогчийн харагцаа шаардлагыг таньж мэднэ
- Өөрийн цаашдын карьерыг төлөвлөх боломжтой болно.

Оюутны дадлага нь:

- Мэргэжлийн онцлог сургалтын хөтөлбөрийн онцлогоос шалтгаалан, 2-3 төрлийн дадлагыг хийж байна
- Нэрний хувьд мэргэжлийн онцлогоос шалтгаалан танилцах, үйлдвэрлэлийн, багшлах гэх мэт олон төрөл байдаг

Оюутны дадлага нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн
- Хээрийн
- Сурган хүмүүжүүлэх

Мөн, дадлагын зорилго, шаардлагаас үүдэн хээрийн-үйлдвэрлэлийн дадлага гэх мэт холимог хэлбэртэй байж болно.

Үйлдвэрлэлийн дадлага

Оюутны танхимд эзэмшсэн онолын мэдлэг, чадварыг практик мэдлэг, чадвар, дадлаар баяжуулах зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага дээр зохион байгуулах дадлагыг **үйлдвэрлэлийн дадлага** гэнэ. Энэ төрлийн дадлага нь танилцах эсвэл мэргэшүүлэх зорилготой байна.

Хээрийн дадлага

Оюутанд хөрс, ус, ургамал, амьтан, чулуулаг зэрэг байгалийн нөөц, археологи, соёл, түүхийн дурсгалуудын хээрийн судалгааны ажиглалт, туршилтын арга зүйг эзэмшүүлэх, онолын мэдлэгийг нь практик дээр бататах, байгалийн нөөц, археологийн олдворыг бие даан тодорхойлж, боловсруулах, дээжийг нь сургалтын үзүүлэн таниулах болон судалгааны материал болгон бэлтгэх чадвар, дадал эзэмшүүлэх зорилгоор хөдөө орон нутагт шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий байгалийн тогтоц газар, түүх соёлын дурсгалт газар, полигонд зохион байгуулах дадлагыг **хээрийн дадлага** гэнэ.

Сурсан хүмүүжүүлэх дадлага

Сурсан хүмүүжүүлэх дадлага нь оюутанд мэргэжлийн болон сэтгэл судлал, сурсан хүмүүжүүлэх зүй, дидактикийн хичээлүүдээр эзэмшсэн мэдлэг, чадвараа батлах үйл ажиллагаанд бүтээгчээр хэрэглэх арга зүйг эзэмшүүлэх үндсэн зорилготой.

Дадлагад гарахдаа анхаарах зүйлс

- Байгууллага урьдчилан судалж мэдээлэлтэй сонголт хийх
- Зөвхөн танхимийн санал болгосон байгууллагаар хязгаарлагдахгүй нэмэлт сонголтүүд байдгийг санах
- Дадлага хийх газраа хариуцсан хүмүүсдээ өөрийнхөө сурахыг хүсч байгаа зүйлээ сайн ойлгуулах
- Дадлагын хугацаандаа хариуцлагатай байж өөрийгөө таниулах
- Дадлагад гарсан оюутан бүрийн тавны нэг нь тэр байгууллагадаа ажигч ордор.

ХОЁР ДУГААР БҮЛЭГ: СУРГУУЛЬ ДЭЭРХ ДАДЛАГА АЖЛЫН ТУРШИЛТ СУДАЛГАА

Судалгаа: 2-1 Өөрийн орж буй хичээлийн сургууль дээрх дадлага ажлыг “Дадлагын хөтөлбөр” боловсруулан орсон туршилтын судалгаа

Бид сургууль дээрх дадлагын үр дүнг тооцохын тулд өөрсдийн ордог мэргэжлийн хичээл дээр судалгаа хийж үзсэн. 2018 оноос эхлэн ХАБ-ын менежмент хичээлийг орж эхэлсэн ба энэ хугацаанд тухайн хичээлийн сургууль дээрх дадлагыг хэрхэн үр дүнтэй зохион байгуулж орж болох боломжийг нээн илрүүлсэн.

Хичээлийг орж эхлэх явцад тухайн хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу дадлага ажлыг явуулахад танхмын сургалттай ижил байдлаар явуулж эхэлсэн бөгөөд энэ нь сургууль дээрх дадлагын чанарыг хангаж чадахуйц биш байсан юм. Иймд тухайн хичээлийн дадлагын ажлыг үр дүнтэй явуулах “Дадлагын хөтөлбөр”-г боловсруулсан.

№	Ерөнхий дадаг	Цэг	Дэд сэдэв	Ноогдох цэг				
				Бүгд	Лекц	Сем	Сургууль дээрх дадлага	
1	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг эрүүл ажуул тогтолцоо	12	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ажуйн тогтолцоо	2	2			
			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ажуйн тогтолцооны үүрэг	2	2			
			ХАБ-н удирдлагын тогтолцооны бүтэц	2	2			
			Компани ХАБ-н удирдлагын тогтолцоогоо хянах нь	2	2			
			ХАБ-н удирдлагын тогтолцоог бий болгох	2				2
2	Аюулгүй байдлын удирдлага	12	ХАБ-н удирдлагын тогтолцооны өөрчлөлт, зорилго, зорилт	2				2
			Зорилон байгуулалт, хариуцан тайлагнах, оролцоо, үүрэг, хариуцлага, эрх мэдэл	2				2
			Дэд шатны удирдлагын үүрэг амлалт	2				2
			Ажиллах хүч ба удирдлагын хариуцлага	2				2
			Ажилтныг татан оролцуулах	2				2
			Аюулгүй байдлын боловсрол олгох	2				2
			Аюулгүй байдлын чанарын удирдлага	2				2
3	Хөдөлмөрийн аюулгүй байдлыг эрүүл ажуйн менежмент	14	1,2-р бүлэг сэдвийн шалгалт	2				2
			Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ажуйн менежмент	2	2			
			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ажуйн удирдлагын тогтолцоо – олон улсын стандарт – OHS 18001	2	2			
4	Эрсдлийн менежмент	14	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ажуйн менежментийг нэвтрүүлэх арга зам	10				10
			Эрсдэл, эрсдлийн удирдлагын тухай ойлголт	2	2			
			Аюул эрсдлийн шинжилгээ	6				6
5	ХАБ-н аюулгүйн сөөлөлийн журал	12	Эрсдлийн үнэлгээ	6				6
			ХАБ-н аюулгүйн сөөлөл ажиллуулах, аюулгүйн сөөлөлийн журал	4	2			2
			ХАБ-н аюулгүйн сөөлөлийг ажиллуулах	6				6

Сургууль дээрх дадлагыг зохион байгуулж ороход дээрх нөхцөл байдал, хүндэрлүүд гарч эхэлсэн учир “Дадлага хичээлийн төлөвлөгөө”-г боловсруулан орж эхэлсэн. Доорх жишээ нь 2020 онд орсон “ХАБ-ын менежмент” хичээлийн сургууль дээрх дадлага ажлыг хэрхэн зохион байгуулж орж болох талаар суралцагчидтай хамтран ярилцаж, ХАБЭА-н тогтолцоог бий болгох сэдвийн цаг дээр боловсруулсан байдаг. “Дадлагын хөтөлбөр”-г СА-ны арга зүйч болон захирлаар батлуулахдаа сургууль дээрх дадлагын цаг, хамрах хүрээ, суралцагчдад олгох мэдлэг, түүнийг чадвар болох нөхцлийг хангаж чадахуйцаар боловсруулан хийсэн.

48 цагийн дадлага хичээлийн цагт тохируулан дадлага ажлыг төлөвлөх

Суралцагч бүрийн оролцоог хангах, ингэснээр зайлшгүй хийх шаардлагатай гэдгийг ойлгох

Хийгдэх ажлууд тодорхой, тухайн хийж буй ажлаараа хичээлийн онолын мэдлэгийг баталгаажуулж, дадлагажих


Багаар ажиллах, бие даан зааварчилгаа өгөх, сургууль дээрх дадлагын үр өгөөж бий болох, үр дүнд хүрэх

БАТЛАВ:  Ш.ОТГОНЖАРГАЛ

ГСА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРАЛ
2020 ОНЫ 10-р САРЫН 27-НӨДӨӨР

УУХАА-ны техникумийн 2а ангиор орж байгаа “ХАБ-ын менежмент” хичээлийн дадлага ажлын төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Эхлэх хугацаа	Хэрэгжих хугацаа	Дуусах хугацаа	Хариуцах зэвс	Хийгдэх ажил
1	Аюулыг мэдээллэх хуудас агуулах	10.29	7 хоног	11.06	Банчиндорж, Мөнхтулга	Сургууль болон ОХХ ойр орчмын аюул эрсдлийг илрүүлэх аюулын мэдээллийн хуудсыг анги бүрт өгөх
2	Хүүхэд бүр сурталт хуудас бэлтгэх	10.30	2 хоног	11.02	Бүгд	ХАБ-ын 2а ангийн хүүхэд тус бүр нэг сэдэв сонгон өгөх түүхээрээ сурталт бэлтгэн элхон байгуулах
3	Ковид 19-ийн мэдээлэл бэлтгэж танилцуулах	11.02	7 хоног	11.09	Тэмүүлэн, Жамьяанпүрэв	Корона вирусын тухай мэдээлэл бэлтгэн, анги бүрт корона вирусээс урьдчилан сэргийлэн мэдээлэл өгөн аюул ослоос сэргийлэн мөн ангийн хүүхдүүдийн маск, ангийн гэр ариутгагч шалгах
4	Ангийн цөөрлөгээ болон цэрэгсэл шалгах	10.28	4н 7 хоног	11.25	Энэжон, Маралмаа	7 хоногт 2-3 удаа анги бүрээр орж ангийн цөөрлөгээ болон шаардагдах хэрэгслийг шалган шаардлага тавин сайжруулах
6	Анхны тусламжийн хайрцаг шалгах, сайжруулах	11.02	27 хоног	11.14	Урангоо, Мөнхонцогц	Анги бүрийн анхны тусламжийн хайрцагийг бүрэн бүтэн байдал, байх ёстой зүйлсийн жагсаалтыг хангуулах
	ХАБ-ын хууль ойлголт өгөх	11.12	27 хоног	11.26	Бүгд	ХАБ-ын хичээлийг үзэж судалсны дараа бүх ангиудад ХАБ-ын хууль эрсдийн ойлголт өгөх
8	АХА зохион байгуулах	11.19	1 хоног	11.19	Бүгд	Бүх ангиудад хууль эрсдийн ойлголт өгөх дараа бүх ангиудыг хамруулан АХА тэмцээн зохион байгуулах
9	ХАБ-ын ажилтантай хамтарч зааварчилгаа өгөх	11.02	7 хоног	11.07	Бүгд	Ангийн оюутнууд сургуулийн ХАБ-ын ажилтантай хоёр хоёроор хуваагдан хамтарч, Политехник коллежийн ажиллагаадад зааварчилгаа өгөн гарын үсэг зургуулах
10	Өглөөний тойрог хийх	11.02	27 хоног	11.14	Мянмарцогт, Хүрэлтүвшин	Анги бүрт өглөөний тойргын тухай мэдээлэл өгөх

Дадлага ажлын төлөвлөгөө боловсруулсан:  М.Базрмаа
ХАБ-2а ангийн оюутнууд

Зураг 2: Дадлагын хөтөлбөрийн загвар жишээ

Судалгаа: 2-1-ийн дүгнэлт


“Дадлагын хөтөлбөр”-г боловсруулж ажилласнаар суралцагч бүр сургууль дээрх дадлагын 2 цагт баригдахгүйгээр, бие даан ажиллах боломжийг олгож байгаа юм. Мөн хүүхэд бүрийн оролцоог хангаж өгснөөр дадлагад суралцагчдыг жигд хамруулж чадаж байна. Хамгийн чухал асуудал нь тухайн мэргэжлээр эзэмших шаардлагатай ур чадварыг өөрсдөдөө бий болгож байна. Жишээ нь: “Хүүхэд бүр хичээл заах” гэсэн төлөвгөөн дээр суралцагчид өөрсдийн авсан сэдвийн дагуу бусад суралцагчдад 30 минутын хичээлийг туршилтаар зааж байгаа. Ингэснээр суралцагчид ХАБ-ын ажилтан болж гарахад үйлдвэр уурхай дээр ИТА болон ажиллагсдад ХАБ-н зааварчилгаа болон сургалтуудыг заах арга барилыг эзэмшин дадлагажиж байна.

“Дадлагын хөтөлбөр”-г боловсруулснаар дараагийн ололттой тал нь суралцагчдыг үнэлэхэд илүү бодитой болж өгнө. Суралцагч бүрийг явцын үнэлгээгээр үнэлэх боловч эцсийн үнэлгээг гаргахад илүү давуу талтай болж өгнө.

Судалгаа: 2-2 "Дадлагын хөтөлбөр" боловсруулан орж буй багш нарын тандалт судалгаа

Мэргэжлийн хичээл орж буй багш нараас сургууль дээрх дадлага ажлыг хэрхэн төлөвлөн орж буйг судалсан. Асуулгад оролцож буй багш нар нь орж байгаа хичээл болон мэргэжлийн чиглэлээс хамааран харилцан адилгүй байсан. Иймд мэргэжлийн багш нарын сургууль дээрх дадлагын ажлыг зохион байгуулах нөхцөл боломжид тулгуурлан 2 хэсэгт ангилан **график-1**-т харууллаа.

График 1



Хүснэгт 1

Сургууль дээрх дадлага	Лабораторитай багш	Онолын кабинеттай багш
Дадлагын ээлжит хичээлийн боловсруулалт	Хийгддэг	Хийгддэг
Тоног төхөөрөмжийн хүрэлцээ болон	Хүрэлцээтэй	Боломжгүй
Багш нарын ачаалал	Цагийн ачаалал их	Цагийн ачаалал их
Суралцагч буйтай тулж харилцах боломж	Муу	Боломжтой
Хичээлийн хуурай, ангийн давхар	Их	Бага
Багшийн өөрийн сэдэл тэмүүлэл	Зарим багш нар	Зарим багш нар
Багшийн дадлага ажил удирдаж байгаа үнэлэмж	Үнэлгээ байхгүй	Үнэлгээ байхгүй
Багш нарын туршлага	Олон жил ажилласан багш нар туршлагатай	Олон жил ажилласан багш нар туршлага

Судалгаа: 2-д-ийн дүгнэлт

"Дадлагын хөтөлбөр"-г боловсруулж ажилласнаар суралцагч бүр сургууль дээрх дадлагын 2 цагт баригдахгүйгээр, бие даан ажиллах боломжийг олгож байгаа юм. Мөн хүүхэд бүрийн оролцоог хангаж өгснөөр дадлагад суралцагчдыг жигд хамруулж чадаж байна. Хамгийн чухал асуудал нь тухайн мэргэжлээр эзэмших шаардлагатай ур чадварыг өөрсдөдөө бий болгож байна. Жишээ нь: "Хүүхэд бүр хичээл заах" гэсэн төлөвгөөн дээр суралцагчид өөрсдийн авсан сэдвийн дагуу бусад суралцагчдад 30 минутын хичээлийг туршилтаар зааж байгаа. Ингэснээр суралцагчид ХАБ-ын ажилтан болж гарахад үйлдвэр уурхай дээр ИТА болон ажиллагсдад ХАБ-н зааварчилгаа болон сургалтуудыг заах арга барилыг эзэмшин дадлагажиж байна.

"Дадлагын хөтөлбөр"-г боловсруулснаар дараагийн ололттой тал нь суралцагчдыг үнэлэхэд илүү бодитой болж өгнө. Суралцагч бүрийг явцын үнэлгээгээр үнэлэх боловч эцсийн үнэлгээг гаргахад илүү давуу талтай болж байна.

"ХАБ-ЫН МЕНЕЖМЕНТ" хичээлийн судалсан оюутны мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний хуудас				
Суралцагчийн нэр <u>М.Баярмаа</u>		Огноо <u>2020.12.01</u>		
№	Шалгуур үзүүлэлт	Авах оноо	Авсан оноо	Гарын үсэг
Очирлын мэдлэг				
1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо	5	5	
2	ХАБЭА-н аюулгүйн зөвлөлийн орон тооны ажилтан ажиллуулах, аюулгүйн зөвлөлийн журам боловсруулах	10	10	
3	ХАБЭА-н менежментийн систем	7	7	
4	Эрсдлийн менежмент	8	8	
Дадлага ажил				
5	ХАБ-ын менежментийн системийн төлөвлөгөө боловсруулахад оролцох	10	10	
6	АХА тэмцээний үйл ажиллагаанд оролцсон	10	8	
7	Суралцагч бүр сургалт өвуулсан	15	15	
8	Ажиллагсдад ХАБ-ын зааварчилгаа өгсөн байдал	10	10	
9	Багаар ажилласан байдал	Аюулыг мэдээллэх хуудас	10	10
		Ангийн ариун цэвэр	10	
		Корона мэдээлэл	10	
		Өглөөний тойрог	10	
10	"ХАБ-ЫН МЕНЕЖМЕНТ" хичээлийн дадлагын цагаар хийгдэх ажлын төлөвлөгөөний дагуу тайлан бичсэн	15	10	
Нийт үнэлгээ		100 оноо	95	

Үнэлгээ хийсэн багш: М.Баярмаа

Зураг 3: Сургууль дээрх дадлагын хөтөлбөрийн үнэлгээний хуудас

ГУРАВ ДУГААР БҮЛЭГ: НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, АЖ АХУЙ НЭГЖИД ХИЙГДСЭН СУДАЛГАА

Судалгаа: 3-1 Дадлагын удирдамжийн харьцуулсан судалгаа

Үйлдвэрлэл дээрх дадлагын үр дүнгийн судалгааг гаргахын тулд бид суралцагчдыг үйлдвэрлэлийн дадлагад явуулахдаа хэрхэн чиглүүлэн гаргаж байна вэ гэдэг дээр дүгнэлт хийх шаардлагатай болсон.

Техникийн боловсрол: Уул уурхайн ХАБ-ын техникчийн ангийн үйлдвэрлэлийн дадлагын удирдамжийн хэсгээс

Дадлагын хөтөлбөр

1. Танилцах дадлагыг дадлагажигч нь сургалтын төлөвлөгөөний дагуу ААНБ-д сургалтын 144 цагийн дадлагыг 4 долоо хоногийн хугацаатай хийнэ.
 - Дадлагад гарахын өмнө дадлагажигч суралцагчийн дадлагын дэвтэр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дадлага хэрхэн хийх талаар зааварчилгаа авна.
 - Дадлагын хугацаанд ААНБ-ын үйл ажиллагаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчиний талаар судлах ажил дээр бичлэн үзэж танилцана.
2. Үйлдвэрлэлийн дадлагыг дадлагажигч нь сургалтын төлөвлөгөөний дагуу ААНБ-д сургалтын 384 цаг /заавал судлах чадамжийн нэгж хичээлийн 144 цаг, үйлдвэр дээрх 240 цаг /-ийг 10 долоо хоногийн хугацаатай хийнэ.
 - Дадлагад гарахын өмнө дадлагажигч суралцагчийн дадлагын дэвтэр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дадлага хэрхэн хийх талаар зааварчилгаа авна.
 - Дадлагын хугацаанд ААНБ дээр хөдөлмөр хамгаалалын хамгаалах хэрэгсэл, үйлдвэрийн ажлын бүсийн орчин, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлагын талаар олж авсан мэдлэгээ бататган хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар дадал эзэмших, ажлын байран дээр дагалдан ажиллах практик дадлыг эзэмшсэн байна.
3. Төгсөлтийн өмнөх дадлагыг дадлагажигч нь сургалтын төлөвлөгөөний дагуу ААНБ-д сургалтын 720 цаг /заавал судлах чадамжийн нэгж хичээлийн 240 цаг, дадлагын 480/-ийг 18 долоо хоногийн хугацаатай хийнэ.
 - Дадлагад гарахын өмнө дадлагажигч суралцагчийн дадлагын дэвтэр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дадлага хэрхэн хийх талаар зааварчилгаа авна.
 - Дадлагын хугацаанд ААНБ дээр өргөх тээвэрлэх машины аюулгүй ажиллагаа, үйлдвэрийн цахилгааны аюулгүй байдал, барилгын салбарын аюулгүй ажиллагаа, өрөмдлөг тээслэгээний аюулгүй ажиллагаа, аж үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар олж авсан мэдлэгээ бататган материал цуглуулан тайлан, диплом бичихэд бэлдэж ирсэн байна.

ДАДЛАГАЖИГЧИЙН ЕРӨНХИЙ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ҮНЭЛГЭЭ

Суралцагчийн овог, нэр:		Ажлынханы чиглэл:	
Хичээлийн жил:		Дадлагын төрөл:	
Дадлага гүйцэтгэсэн хугацаа:	Эхлэх: Дуусах:	Дадлагын боломжтой:	

№	Дүн шинжилгээний өмнөт	Дүн шинжилгээний өмнөт					Нэмэлт тайлбар
		1	2	3	4	5	
1	Ажилд хандах ерөнхий байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд						
2	Шинэ даалгаврыг биелүүлж буй байдал						
3	Хувийн зохион байгуулалт						
4	Ажил хийх сонирхол						
5	Ажлын хурд						
6	Ажлын чанар						
7	Найдвартай байдал						
8	Нямбай байдал						
9	Тэвчээр, ачаалал даах чадвар						
10	Хамт олонтойгоо харьцах харилцаа						
11	Цаг баримтлах байдал						
12	Алдаа дутагдлаа хүлээн зөвшөөрөх байдал						
13	Мэргэжлийн дагуу мэдээлэл эрэлхийлэх байдал (хамтран ажиллагаанд, интернет г.м.)						
14	Мэргэжлийн мэдлэгээ ашиглах буй байдал						
15	Дадлагын өдрийн тэмдэглэл хөтлөлт						
16	Бие даах байдал						
Үнэлгээний голч							

Юуг хөгжүүлэх шаардлагатай вэ?.....

Суралцагчид ямар дэмжлэг хэрэгтэй вэ?.....

Суралцагчийн зүгээс ямар хувь нэмэр оруулах боломжтой вэ?.....

Үнэлгээ хийсэн:
Дадлага удирдсан ажилтан:

**Мэргэжлийн боловсрол: ХММО-ын ангийн танилцах
дадлагын удирдамжийн хэсгээс**

Дадлагын хөтөлбөр

1. Танилцах дадлагыг дадлагажигч нь сургалтын төлөвлөгөөний дагуу ААНБ-д хийнэ.
 - Дадлагад гарахын өмнө дадлагажигч суралцагчийн дадлагын дэвтер, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дадлага хэрхэн хийх талаар зааварчилгаа авч дадлагын томилолтоо бөглүүлэн 3-ласан гэрээнд сургууль болон өөрөө гарын үсэг зурж баталгаажуулж авч явна.
 - Дадлагын хугацаанд ААНБ-ын үйл ажиллагаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар судлаж ажлын байран дээр хүнд машин механизмын засварын үйл ажиллагаатай биечлэн үзэж танилцана.
2. Үйлдвэрлэлийн дадлагыг дадлагажигч нь сургалтын төлөвлөгөөний дагуу Үйлдвэр дээрх дадлага сургалтын 200 цагийг 5 долоо хоногийн хугацаатай хийнэ.
 - Дадлагад гарахын өмнө дадлагажигч суралцагчийн дадлагын дэвтер, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дадлага хэрхэн хийх талаар зааварчилгаа авч дадлагын томилолтоо бөглүүлэн 3-ласан гэрээнд сургууль болон өөрөө гарын үсэг зурж баталгаажуулж авч явна.
 - Дадлагын хугацаанд ААНБ дээр хөдөлмөр хамгаалалын хамгаалах хэрэгсэл, үйлдвэрийн ажлын бүсийн орчин, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага болон ХММ-ын бүтэц, зохион байгуулалт, техник үйлчилгээ, М ангилалын жолоодлого, ХММ-ын жолоодлогын талаар олж авсан мэдлэгээ бататган хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар дадал эзэмшиж, ажлын байран дээр дагалдан ажиллах практик дадлыг эзэмшсэн байна.
3. Төгсөлтийн өмнөх дадлагыг дадлагажигч нь сургалтын төлөвлөгөөний дагуу ААНБ-дад сургалтын 268 цагийг 6 долоо хоногийн хугацаатай хийнэ.
 - Дадлагад гарахын өмнө дадлагажигч суралцагчийн дадлагын дэвтер, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дадлага хэрхэн хийх талаар зааварчилгаа авч дадлагын томилолтоо бөглүүлэн 3-ласан гэрээнд сургууль болон өөрөө гарын үсэг зурж баталгаажуулж авч явна.
 - Дадлагын хугацаанд ААНБ дээр техникийн үг хэллэг, ХММ-ын бүтэц, зохион байгуулалт, техник үйлчилгээ, М ангилалын жолоодлого, ХММ-ын жолоодлого, ХММ-ын гидравлик системийн оношлогоо, засвар, ХММ-ын электрон системийн оношлогоо, засвар, эвдрэл гэмтлийн дүн шинжилгээ, шатах тослох материалын хэрэглээ, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар олж авсан мэдлэгээ бататган материал цуглуулсан тайлан бичихэд бэлдэж ирнэ.

ДАДЛАГАЖИГЧ ӨӨРТӨӨ ӨГӨХ ХЯНАЛТ-ҮНЭЛГЭЭ

Дадлагажигчийн нэр:			
Үнэл	Гүйцэтгэсэн ажилбар	Өмнө	
		Боловсролт	Ажлын
Өмнөхөн хугацаанд ажиллаж гүйцэтгэж чадсан эсэх, угүй бол яагаад:			
Салт болсон зүйлс:			
Салтгүй болсон зүйлс:			
Дараагийн удаад ажиллаж гүйцэтгэх зүйлс:			
Хийсэн ажлын гүйцэтгэлдээ:		- маш сэтгэл хангалуун - сэтгэл хангалуун - тийм ч сэтгэл хангалуун бус - сэтгэлд хүрсэнгүй	
Дадлагажуулагч багшаас өгсөн зөвлөгөөнийг тэмдэглэл:			

Гүйцэтгэсэн:

Хянасан:

Дадлага гүйцэтгэгч

Дадлага удирдсан ажилтан

Зураг 5: Мэргэжлийн боловсролын 2,5 жилийн танилцах дадлагын удирдамжийн хэсгээс

Судалгаа: 3-1-ийн дүгнэлт

Дээрх 2 удирдамжид харьцуулалт хийхэд удирдамж нь сурацлагын хандлага төлөвшилийн үнэлгээг ажиг олгогч үнэлэх боломж олгосон, мөн сурацлагид өөрсдийгөө дүгнэх боломж олгосон нь маш давуу талтай харагдаж байна. Харин бидний хамгийн чухал хэсэг болох дадлагын хөтөлбөр буюу үйлдвэрлэл дээр мэдэж, дадлагатай хэсэгт төдийлөн ач холбогдол өгөөгүй, зөвхөн өгүүлбэр төдийхнөөр бичиж өрсөн нь сул талтай. Дадлагад явж байгаа сурацлагчид тухайн хичээлээр мэдэж авсан мэдлэгээ дадлага, үр чадвар болох үндсэн хэсгийг анхаарч уншихгүй, үйлдвэрлэл дээр очоод зөвхөн дадлага удирдаж байгаа ажиглагч болон ИТА-ны зааварчилгаагаар дадлагаа хийн ирж, дадлагын тайлан хамгаалах явцад үндсэн онолын мэдлэгийн чиглэлээр асуулт асуухад хүндрэлтэй болж ирдэг.

Судалгаа: 3-2 үйлдвэр аж ахуй нэгжид ҮСД-ыг хэрхэн зохион байгуулж буйд хийгдсэн судалгаа

Мэргэжлийн боловсролын 2-р курсын ХММО-ын мэргэжлээр сурацаж байгаа сурацлагчдын дадлага хийсэн аж ахуй нэгжүүдээс сонгон авч судалгаа хийсэн. Судалгааны асуултыг доорх хүснэгт-2-ийн дагуу авсан байна.

№	Асуулга	1	2	3	4	5	6	7
	Манай сургуулиас дадлага хийж байгаа сурацлагчдын удирдамжтай танилцсан уу?	сурацлагчдын удирдамжтай танилцсан уу?	Сурацлагчдын үйлдвэр дээрх дадлагын хэрэгцээ шаардлагыг асуудаг уу?	Сурацлагчдыг удирдсан ажилтан хяналтын хуудсыг бөглөдөг уу?	Сурацлагчдын өөрийн дадлагын хөтөлбөрийг хянадаг уу?	Онолын мэдлэгийн дагуу шаардлагатай материалгаар хангадаг уу?	Сурацлагчдын мэдлэг чадварыг үнэлж дагнэхэд хүндрэлтэй байдаг уу?	Үнэлгээний бэлэн хуудастай байвал танд үнэлгээ өгөхөд амар байх уу?
Аж ахуй нэгж 1	үгүй	үгүй	Заримдаа	үгүй	үгүй	үгүй	Би дагнэдэггүй	Тийм
Аж ахуй нэгж 2	үгүй	үгүй	Тийм	үгүй	үгүй	үгүй	Би дагнэдэггүй	Тийм
Аж ахуй нэгж 3	тийм	тийм	Тийм	үгүй	үгүй	үгүй	Би дагнэдэггүй	Тийм
Аж ахуй нэгж 4	Тийм	Тийм	Тийм	үгүй	Заримдаа	үгүй	Би дагнэдэггүй дарга нар...	Тийм
Аж ахуй нэгж 5	үгүй	үгүй	Тийм	үгүй	үгүй	үгүй	Би дагнэдэггүй, хүндрэлтэй	Тийм

Хүснэгт 2

Судалгаа 3-2-ийн дүгнэлт

Манай сургуультай хамтран ажиллаж, оюутан дадлагажнуудад Шивээ-Овоо ХК, МАК-ЦЕМЕНТ үйлдвэр, Мон-Икс ХХК, Бор-Өндөр Барилгын уурхай, Азсаан ХХК зэрэг байгууллагуудын оюутан дадлагажнууд ажилласан ажилчинтай холбогдож дээрх асуулгын дагуу судалгаа авлаа. Оюутант дадлага хийлгэхээс өмнө тухайн байгууллагын талаар тоног төхөөрөмж, хүний нөөцийн багтаамжийн тухай судалгаат авч ажиллавал оюутны дадлага үр дүнтэй болох эхний алхам юм. Жишээлбэл Шивээ-Овоо ХК-д токарын мэржжлээр үйлдвэрлэлийн дадлага хийхээр очиход тухайн цех нэг л токартай тэр машин нь байгууллагын ачааллаа даахгүй ажиллаж байдаг. Шинэ ирсэн оюутнаар шууд гарах бүтээгдэхүүн хийлгэх нь эрсдэл өндөртэй байдаг учир тухайн үйлдвэрлэлийн дадлага танилцах дадлага болон хувирдаг. Оюутны дадлага ажлын үнэлгээг тухайн алба тасрын дарга нар бөглөдөг харин яг дадлагажнууд буй ажилчинд гол мэдлэгийг олгодог, харьцаж ажилладаг нь дадлага ажлын үнэлгээ маш буруу явагдаж байна. Мөн судлагаанд оролцсон ихэнх хүмүүс дадлагаж байгаа оюутнуудын дадлага ажлын үлдэгдэлтэй уншиж танилцах нь бараг 10 хувьтай байгаа нь ажилчинд ажилдаа анхаарахаас биш бичиг цаастай холбоотой ажигд хойрго ханддаг нь тодорхой байна. Тиймээс оюутны дадлага ажлын үлдэгдэлтэй шинэчилж мэржжил болгоноор үнэлгээний хуудас гаргаж тухайн үнэлгээний хуудсыг оюутан өөрөө өөрийгөө үнэлдэг тухайн үнэлгээг дагалдуулж байгаа ажлын бие үнэлдэг түүнийг удирдах албан тушаалтан баталгаажуулдаг байвал бичиг цаас болоод цаг хугацааг хэмнэж дээрээс нь хамгийн гол нь дадлагын үр дүн болон үнэлгээ бодит болно гэж дүгнэж байна.

Судалгаа:3-3 Дадлагын удирдамжид дадлагын хөтөлбөрийг сайжруулж оруулснаар ҮСД-д гарах үр дүнгийн өөрчлөлт болон ажил олгогч, үйлдвэр, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх боломж

Нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг сайжруулахын тулд бид олон арга хэлбэрүүдийг ашиглаж байгаа. Үүнийг нэг нь суралагчдыг үйлдвэрлэлийн дадлагад хамруулах, тэдний мэдлэгийг үнэлж дүгнэх, хамтран ажиллах, цаашид ажлын байраар хангах байдаг. Тэгвэл ажил олгогчдыг үйлдвэрлэлийн дадлагыг чиглүүлэн ажиллах, суралцагчдыг үнэлж дүгнэхэд амар болгох тал дээр бид хамтран ажиллах нь зүйтэй.

Иймд доорх саналыг дэвшүүлж байна. Энэ нь дээрх **зураг-4,5-т** харуулсан удирдамжийн

дадлагын хөтөлбөр хэсэгт “Дадлагын хөтөлбөр”-г оруулж өгөх, мөн дадлага ажлыг үнэлэх хяналтын хуудсыг боловсруулж өгөх юм. Ингэснээр ажил олгогч, ИТА болон дадлага удирдаж буй ажилтанд хялбар байх боломжийг олгож хамтран ажиллахад хялбар болж өгнө.

ХММО-ын мэргэжлийн ангийн үйлдвэр дээрх дадлагын хөтөлбөр загвар

дадлагажигчийг үнэлэх хуудас

Гүйцэтгэсэн ажилбар	Гүйцэтгэх ажлын хугацаа	Оюутан өөрөө	Дадлагажуулсан ажилтан	ИТА, удирдах албан тушаалтан
Ажлын байрны эмх цэгц	Өдөр бүр			
ХАБ-ыг дагаж мөрдсөн байдал	Өдөр бүр			
ААНБ дээр техникийн үг хэллэгийг мэдэх. Нэршлийн тоо хэмжээ	Өдөр бүр			
Тухайн байгууллагад ажиллаж байгаа ХММ-ын тоо ширхэг, техникийн үзүүлэлтийг мэдэх	Дадлагын хугацаанд			
Багаж хэрэгсэлтэй танилцах, нэрлэж сурах	Дадлагын хугацаанд			
ХММ-ын бүтэцтэй танилцах	Дадлагын хугацаанд 2 удаа			
ХММ-ын техник үйлчилгээ хийх	Дадлагын хугацаанд 2 удаа			
ХММ-ын жолоодлогыг хийж туршиж үзэх	Дадлагын хугацаанд 2-с дээш			
ХММ-ын гидравлик системийн оношлогоо хийж буй ажилтныг ажиглах, асуулт тавих	1-с дээш удаа			
ХММ-ын электрон системийн оношлогоо хийж буйг ажиглах	1-с дээш удаа			
Засвар, эвдрэл гэмтлийн үед дадлагжуулж буй ажилтанд туслах	Өдөр бүр			
Шатах тослох материалын хэрэглээг хэрхэн хийж байгаа, хаанаас авдаг зэрэгтэй танилцах	Дадлагын хугацаанд			
Ерөнхий үнэлгээ				

Дадлагын үнэлгээг 1-5 хүртлэх оноогоор дүгнэх

Гүйцэтгэсэн:

Хянасан:

Баталгаажуулсан:

Дадлага гүйцэтгэгч

Дадлага удирдсан ажилтан

Удирдах албан тушаалтан

Зураг 6: Үйлдвэр дээрх дадлагын удирдамжийн загвар

Ерөнхий дүгнэлт

Нийгмийн түншлэл болон сургуулийн хамтын ажиллагааны гол үндсэн чиглэл нь төсөгчдийг ажлын байраар хангах, ҮСД хийлгэх үйл ажиллагааг зохицуулахад оршдог. Тухайн суралцангийн амжилттай суралцах, мэдсэн мэдлэг, үр чадварыг хөгжүүлэх үнэлж, дүгнэх нь бидний хамтын ажиллагаа, уялдаа холбооноос ихээхэн шалтгаална. Сайн бэлтгэгдэн гарсан төсөгч нь сайн ажиглагч болно.

Иймд бидний хамтын ажиллагааны нэг хэсэг болох суралцангийн ҮСД-ыг үр дүнтэй зохион байгуулж, хамтран ажиглах хэрэгцээ шаардлага байна.

ҮСД-ын уялдаа холбоо нь сургууль дсрх дадлага, үйлдвэрлэлийн дадлага, төсөлтийн өмнөх дадлага гэсэн үе шаттай байдаг нь харицан нэг нэгэндээ нөлөөтэй байдаг аар хийгдэх шаардлагатай гэдгийг харуулдаг.

Сургууль дээрх дадлагын үр өгөөжийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн дадлагад гаргахдаа манай сургууль түлхүү анхаарч ажиглах хэрэгцээтэй бөгөөд ҮСД-ын удирдамжийг дахин шинэчлэн сайжруулж, ажиг олгогчид суралцангидтай шууд харицах боломжийг нэмэгдүүлсэн байдлааа зохион байгуулах нь зүйтэй байна.

Бид суралцангийн эцсийн үнэлгээг гаргахдаа ажиг олгогчоос өрсөн үнэлгээ өөрсдийн үнэлгээтэй харьцуулан гаргадаг тул тухайн үнэлгээ бодитой үнэн зөв үнэлэгдэх, шаардлагатай.

Цаашид давуу үлж буй санаа

Дадлагын удирдамжид суралцангийн хийх дадлагын хөтөлбөр нь ойгомжтой хялбар байдлаар төлөвж өгөх

Ажиг олгогч, ажиглагч, суралцангид өөрсдийгөө үнэлэх гэсэн 3 түвшний үнэлгээг холбож өгснөөр суралцангийн бодитой үнэлэх боломжтой болно. Энэ боломжийг бид бүрдүүлж өгөх

Суралцангийн насны онцлог, үзэж судалсан хичээлийн агуулга зэрэгт уялдуулан удирдамжийг бодовсруулах

Ном зүй

- Мэргэжлийн боловсролын салбарын багш нарын анхдугаар зөвлөгөөн 2019он- Сайд асан Чинзоригийн илтгэл
- Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 2016-2021
- МБС-ын тухай хууль 2019 он шинэчилсэн найруулга
- Говьсүмбэр Политехник коллежийн ҮСД-ын гурвалсан гэрээ
- WWW.GOOGLE.MN
- WWW.BVTEELSURGALT.MN
- WWW.SLIDESHARE.NET
- https://prezi.com/niei_fxwectv/presentation/ Төсөлт ажил-Хүүхэд хөгжил